# НИЙСЛЭЛИЙН
# ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 09 өдөр | Дугаар А/504 | Улаанбаатар хот

Хөрөнгө хүлээн авах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2019 оны А/531 дүгээр захирамж, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын “Үнэлгээний хороо байгуулах тухай” 2019 оны А/340 дүгээр захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Од пропертиз” ХХК-тай байгуулсан “Цас цэвэрлэгээ, усалгааны автомашин /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг/” СХД/ЦЦУАМ/2019 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй хөрөнгийг хүлээн авах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор батлсугай.

2. “Цас цэвэрлэгээ, усалгааны автомашин /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг/” нийлүүлэх ажлын тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг /С.Ариунжаргал/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ҮНЭНБАТ

11505000145?

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны .12... дугаар сарын .09...өдрийн.А/504.дугаар тушаалын хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

| | | |
|---|---|---|
| | С.Ариунжаргал | Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга |

Гишүүд:

| | | |
|---|---|---|
| | Л.Алтанхуяг | Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга /Зөвшилцсөнөөр/ |
| | Ж.Нямхүү | Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Агаарын бохирдолтой тэмцэх тасгийн дарга /Зөвшилцсөнөөр/ |
| | Т.Вандандорж | Сонгинохайрхан дүүргийн Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ-ын захирал /Зөвшилцсөнөөр/ |
| | Г.Янжиндулам | Сонгинохайрхан дүүргийн Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ-ын ерөнхий нягтлан бодогч /Зөвшилцсөнөөр/ |

Нарийн бичгийн дарга:

| | | |
|---|---|---|
| | А.Эрдэнэмөнх | Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн |